



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

___ оны __ сарын __ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

Маягтын загвар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2, Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 77.7.3, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Хувь хүний орлогын албан татварын хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3-т заасан “Бичил худалдаа, ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний албан татвар төлсөн гэрчилгээний маягт”-ыг 1 дүгээр, “Гэрчилгээг хэрэглэх заавар”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Маягт, зааврыг мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг харьяа татварын нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Татварын орлогын газар /Д.Цогтжаргал /-т даалгасугай.

ДАРГА

Б.ЗАЯАБАЛ



Монголын Татварын Алба

Маягт

БИЧИЛ ХУДАЛДАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ХУВИАРАА ЭРХЛЭГЧ ИРГЭНИЙ АЛБАН ТАТВАР ТӨЛСӨН ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР

Албан татвар төлсөн гэрчилгээ (Бичил худалдаа, ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч хувь хүн) 1. Татвар ногдуулсан ЗЗН-ийн нэр: 2. ТТД: 3. Хувь хүний овог: 4. Нэр: 5. ТТД: 6. Эрхлэх худалдаа, ажил, үйлчилгээний төрөл: 7. Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа: 8. Татвар төлсөн хугацаа: 9. Төлсөн дүн:  Албан татвараа хуулийн хугацаанд төлсөн татвар төлөгч танд баярлалаа. Эх сурвалж: https://itax.mta.mn www.e-tax.mta.mn	10 CM
8 CM	

“АЛБАН ТАТВАР ТӨЛСӨН ГЭРЧИЛГЭЭ”-Г ХЭРЭГЛЭХ ЗААВАР

1.Татварын алба нь “Хувь хүний орлогын албан татварын хууль”-ийн 26 дугаар зүйлийн 26.2-т заасны дагуу бичил худалдаа эрхлэгч, ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг олгох орон нутгийн засаг захиргааны нэгжийн холбогдох албан тушаалтан нь татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангаас татвар төлөгчийн цахим төлбөрийн баримтыг үүсгэх, татвар төлөгчийн албан татвар төлсөн гэрчилгээг хэвлэн татвар төлөгчид олгох боломжийг хангана.

2.Татварын алба нь бичил худалдаа эрхлэгч, ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгчийн татварын орлогыг төвлөрүүлэх дансыг холбогдох төсвийн ангиллын дагуу төрийн санд байршуулна.

3.Татвар төлөгч нь албан татвар төлөгчийн гэрчилгээг татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангаас хэвлэн авах боломжтой байна.

4.Хэвлэмэл маягт дараах мэдээллийг агуулна:

- 1.1.татвар ногдуулсан засаг захиргааны нэгжийн нэр;
- 1.2.татвар ногдуулсан засаг захиргааны нэгжийн татвар төлөгчийн дугаар;
- 1.3.бичил худалдаа, ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч хувь хүний овог;
- 1.4.татвар төлөгчийн нэр;
- 1.5.татвар төлөгчийн дугаар;
- 1.6.эрхлэх худалдаа, ажил, үйлчилгээний төрөл: (Татвар төлөгчийн эрхэлж байгаа бичил худалдаа, ажил, үйлчилгээг зорчигч, ачаа тээврийн үйлчилгээ, худалдаа, үйлчилгээ гэсэн ангиллаас сонголтоор)
- 1.7.худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа;
- 1.8.татвар төлсөн хугацаа;
- 1.9.татварын орлогын данс
- 1.10.төлсөн албан татварын дүн.

5.“Хувь хүний орлогын албан татварын хууль”-ийн 27 дугаар зүйлийн 27.3 заасны дагуу бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох эрх бүхий орон нутгийн засаг захиргааны нэгж нь албан татварын тайланг харьяа татварын албанд дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлж, тооцоо нийлнэ.